



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2025/114/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл  
Утас: 70422954 Цахим хаяг: [aigulj@audit.gov.mn](mailto:aigulj@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Назгүл  
Утас: 99427301 Цахим хаяг: [NazgulD@audit.gov.mn](mailto:NazgulD@audit.gov.mn)  
Аудитор: Х.Манаргүл  
Утас: 95429524 Цахим хаяг: [manargulx@audit.gov.mn](mailto:manargulx@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Ө.ТАНАТ  
ТАНАА

2025.02.25 № 199  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлох үйл явдал гараагүй байна.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

832502000240

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>276,424,077.17</u></b>	<b><u>258,114,820.93</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	23,085,950.00	12,895,743.63
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	23,085,950.00	12,895,743.63
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	23,085,950.00	12,895,743.63
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	23,085,950.00	12,895,743.63
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	610,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	610,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	610,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	252,728,127.17	245,219,077.30
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	160,180,142.87	166,971,917.41
35110	Тусгай зориулалттай материал	160,180,142.87	166,971,917.41
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	91,825,768.30	77,524,943.89
35410	Бичиг хэргийн материал	14,752,960.90	7,874,473.40
35420	Аж ахуйн материал	10,412,788.51	10,260,536.51
35430	Сэлбэг хэрэгсэл	1,356,400.00	5,228,400.00
35440	Түлш, шатах тослох материал	2,478,943.91	119,393.91
35450	Барилгын засварын материал	2,502,000.00	2,502,000.00
35470	Бусад хангамжийн материал	60,322,674.98	51,540,140.07
35600	Мал амьтад	722,216.00	722,216.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,901,423,920.63</u></b>	<b><u>2,943,938,834.29</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,901,423,920.63	2,943,938,834.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,242,377,920.93	2,288,512,834.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,600,672,983.00	1,600,672,983.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(197,791,298.88)	(236,987,272.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	426,810,157.14	724,816,427.53
39204	Хуримтлагдсан элэгдэл	(182,480,200.59)	(302,190,638.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	766,487,045.26	655,310,459.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(384,753,664.27)	(353,367,077.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,576,661.66	74,182,103.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,824,550.69)	(41,499,630.76)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	38,575,360.99	38,575,360.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	305,427,716.23	305,427,716.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	(145,322,288.92)	(176,427,596.28)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	659,045,999.70	655,425,999.66
39301	Програм хангамж	3,800,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.30)	(170,000.34)
39303	Бусад биет бус хөрөнгө	655,396,000.00	655,396,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,177,847,997.80</u></b>	<b><u>3,202,053,655.22</u></b>

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,177,847,997.80</u></b>	<b><u>3,202,053,655.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,177,847,997.80	3,202,053,655.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,572,850,023.70	1,572,850,023.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,100,971,276.98	1,125,176,934.40
51210	Өмнөх үеийн үр дүн	1,100,971,276.98	1,100,971,276.98
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,205,657.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	504,026,697.12	504,026,697.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,177,847,997.80</u></b>	<b><u>3,202,053,655.22</u></b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,183,986,136.40</b>	<b>7,417,226,773.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>425,417,148.40</b>	<b>708,719,873.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	412,600,148.40	708,719,873.89
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	234,694,585.00	162,394,058.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,797,985.00	162,394,058.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	163,896,600.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	143,077,563.40	525,080,520.39
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	34,828,000.00	21,245,295.50
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	12,817,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	12,817,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,758,568,988.00</b>	<b>6,708,506,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,614,781,300.00	6,384,886,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,614,781,300.00	6,384,886,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	143,787,688.00	323,620,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,229,700.00	198,799,570.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	430,000.00	99,424,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	137,127,988.00	25,397,030.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,970,132,073.63</b>	<b>7,181,835,699.21</b>

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,970,132,073.63</b>	<b>7,181,835,699.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,548,915,388.63</b>	<b>6,125,962,821.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,805,753,287.26</b>	<b>4,936,169,903.59</b>
210101	Үндсэн цалин	1,943,351,447.00	2,320,494,066.09
210102	Нэмэгдэл	1,862,401,840.26	1,582,250,716.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	71,546,842.00
210104	Урамшуулал	-	444,349,563.82
210105	Гэрээт ажлын хөлс	-	517,528,715.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,438,375.74</b>	<b>94,439,935.78</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	76,438,375.74	94,439,935.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>114,045,788.00</b>	<b>154,498,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,682,300.00	26,182,300.00
210302	Түлш, халаалт	81,983,988.00	107,316,500.00
210303	Цэвэр, бохир ус	7,379,500.00	20,999,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>205,232,454.00</b>	<b>329,107,728.91</b>
210401	Бичиг хэрэг	23,527,710.00	16,454,850.00
210402	Тээвэр, шатахуун	150,417,930.00	185,615,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,837,968.00	35,916,967.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,043,850.00	87,974,339.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	13,404,996.00	3,146,312.91
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>19,864,100.00</b>	<b>90,018,468.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	1,036,468.00
210502	Хоол, хүнс	17,799,500.00	81,822,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,884,600.00	7,160,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>67,643,088.00</b>	<b>111,967,427.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,140,000.00	40,476,827.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,038,700.00	1,727,500.00
210604	Урсгал засвар	59,464,388.00	69,763,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>19,354,400.00</b>	<b>51,865,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	19,354,400.00	51,865,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,900,527.00</b>	<b>19,462,731.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,967,600.00	15,333,832.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,174,141.00	1,277,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	329,600.00	582,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	2,190,046.00	933,759.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	239,140.00	14,740.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>227,683,368.63</b>	<b>338,433,026.93</b>

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,983,300.00	5,611,743.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,743,251.54	12,138,093.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	186,956,817.09	320,683,189.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>421,216,685.00</b>	<b>1,055,872,878.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>399,649,500.00</b>	<b>1,015,468,788.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,366,050.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,207,272.00	547,303,544.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	131,586,428.00	368,787,665.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	108,489,750.00	99,377,579.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,567,185.00</b>	<b>40,404,090.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,567,185.00	40,404,090.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>213,854,062.77</u></b>	<b><u>235,391,074.68</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	211,185,417.26
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	211,185,417.26
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(211,185,417.26)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>213,854,062.77</u></b>	<b><u>24,205,657.42</u></b>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>4,852,922,923.00</u></b>	<b><u>6,879,052,751.63</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>94,353,935.00</b>	<b>170,545,851.63</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	94,353,935.00	170,545,851.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,353,935.00	170,545,851.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,267,985.00	163,004,058.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,085,950.00	7,541,793.63
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,758,568,988.00</b>	<b>6,708,506,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,614,781,300.00	6,384,886,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,614,781,300.00	6,384,886,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	143,787,688.00	323,620,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,229,700.00	198,799,570.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	430,000.00	99,424,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	137,127,988.00	25,397,030.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>4,819,486,929.00</u></b>	<b><u>6,839,939,990.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,819,486,929.00</b>	<b>6,839,939,990.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,396,930,144.00</b>	<b>5,779,160,668.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,823,284,000.00	4,937,339,600.00
210101	Үндсэн цалин	1,978,195,022.34	2,321,044,290.18
210102	Нэмэгдэл	1,303,739,377.66	1,582,870,188.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,600,000.00	71,546,842.00
210104	Урамшуулал	77,284,704.82	444,349,563.82
210105	Гэрээт ажлын хөлс	406,464,895.18	517,528,715.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	81,846,700.00	99,789,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	81,846,700.00	99,789,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	114,045,788.00	151,990,300.00
210301	Гэрэл, цахилгаан	24,682,300.00	26,182,300.00
210302	Түлш, халаалт	81,983,988.00	104,808,500.00
210303	Цэвэр, бохир ус	7,379,500.00	20,999,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	193,972,768.00	263,363,706.00
210401	Бичиг хэрэг	24,875,900.00	23,066,360.00
210402	Тээвэр, шатахуун	151,550,600.00	185,763,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,757,668.00	35,916,968.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,600.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,485,000.00	18,216,668.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,423,500.00	84,472,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	1,600,000.00
210502	Хоол, хүнс	17,743,500.00	81,372,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	74,886,088.00	131,342,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,945,800.00	38,995,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,135,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	62,805,288.00	90,347,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,834,400.00	51,865,300.00
210702	Дотоод албан томилолт	18,834,400.00	51,865,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,786,900.00	20,923,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,550,000.00	16,337,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	659,800.00	1,277,800.00

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	329,600.00	582,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	2,247,500.00	1,405,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,850,000.00</b>	<b>38,073,962.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,140,000.00	27,211,362.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,710,000.00	10,862,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>422,556,785.00</b>	<b>1,060,779,322.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>400,989,600.00</b>	<b>1,020,375,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,750,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,207,300.00	547,303,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	131,586,500.00	368,787,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	105,445,800.00	104,283,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,566,385.00</b>	<b>40,404,090.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,566,385.00	40,404,090.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>800.00</b>	<b>32.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	800.00	32.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>33,435,994.00</u></b>	<b><u>39,112,761.63</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>18,115,844.00</b>	<b>49,303,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18,115,844.00</b>	<b>49,303,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>18,115,844.00</b>	<b>49,303,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,115,844.00	49,303,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(18,115,844.00)</u></b>	<b><u>(49,303,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>15,320,150.00</b>	<b>(10,190,238.37)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>7,765,800.00</b>	<b>23,085,950.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>23,085,950.00</b>	<b>128,957,436.63</b>

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,572,850,023.70	504,026,697.12	1,100,971,276.98	3,177,847,997.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,572,850,023.70	504,026,697.12	1,100,971,276.98	3,177,847,997.80

D08	Тайлант үеийн үр дүн			24,205,657.42	24,205,657.42
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,572,850,023.70	504,026,697.12	1,125,176,934.40	3,202,053,655.22

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	6,507,486,300.00	6,507,486,300.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,507,486,300.00	6,507,486,300.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,504,843,100.00	5,504,843,100.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,904,939,600.00	4,904,939,600.00
210101	Үндсэн цалин	2,316,404,400.00	2,292,694,290.18
210102	Нэмэгдэл	1,505,988,000.00	1,578,820,188.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,080,000.00	71,546,842.00
210104	Урамшуулал	500,000,000.00	444,349,563.82
210105	Гэрээт ажлын хөлс	512,467,200.00	517,528,715.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	99,789,900.00	99,789,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	99,789,900.00	99,789,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	148,990,300.00	148,990,300.00
210301	Гэрэл, цахилгаан	23,182,300.00	23,182,300.00
210302	Түлш, халаалт	104,808,500.00	104,808,500.00
210303	Цэвэр, бохир ус	20,999,500.00	20,999,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	205,028,100.00	205,028,100.00
210401	Бичиг хэрэг	21,735,900.00	21,735,900.00
210402	Тээвэр, шатахуун	173,107,200.00	173,107,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,000,000.00	7,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,785,000.00	2,785,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,004,000.00	18,004,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	16,204,000.00	16,204,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	75,702,200.00	75,702,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,545,000.00	17,545,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	56,157,200.00	56,157,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	31,165,300.00	31,165,300.00

210702	Дотоод албан томилолт	31,165,300.00	31,165,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,723,700.00</b>	<b>18,723,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,137,800.00	14,137,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,277,800.00	1,277,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	582,600.00	582,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	1,405,500.00	1,405,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,002,643,200.00</b>	<b>1,002,643,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,002,643,200.00</b>	<b>1,002,643,200.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	547,303,800.00	547,303,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	368,787,800.00	368,787,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	86,551,600.00	86,551,600.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,507,486,300.00</b>	<b>6,547,890,358.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>6,384,886,300.00</b>	<b>6,384,886,300.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	6,384,886,300.00	6,384,886,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>122,600,000.00</b>	<b>163,004,058.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,600,000.00	163,004,058.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>155.00</b>	<b>155.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	129.00	129.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	21.00	21.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>155.00</b>	<b>155.00</b>
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	151.00	151.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	4.00	4.00

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>96,646,888.00</b>	<b>323,620,568.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>96,646,888.00</b>	<b>323,620,568.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>96,646,888.00</b>	<b>323,620,568.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	32,400,000.00
Үндсэн цалин		28,350,000.00
Нэмэгдэл		4,050,000.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,584,588.00</b>	<b>3,000,000.00</b>

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Гэрэл, цахилгаан	1,500,000.00	3,000,000.00
Түлш, халаалт	10,484,588.00	
Цэвэр, бохир ус	2,600,000.00	
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,669,968.00</b>	<b>58,335,606.00</b>
Бичиг хэрэг	11,140,000.00	1,330,460.00
Тээвэр, шатахуун	5,013,000.00	12,656,510.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,516,968.00	28,916,968.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	15,431,668.00
<b>Нормативт зардал</b>	<b>2,877,600.00</b>	<b>66,468,000.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,300,000.00
Хоол, хүнс	2,877,600.00	65,168,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,144,732.00</b>	<b>104,943,000.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	14,761,644.00	70,753,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	135,000.00	
Урсгал засвар	22,248,088.00	34,190,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,810,000.00</b>	<b>20,700,000.00</b>
Дотоод албан томилолт	7,810,000.00	20,700,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>350,000.00</b>	<b>2,200,000.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000.00	2,200,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,210,000.00</b>	<b>35,573,962.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		27,211,362.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,210,000.00	8,362,600.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>143,787,688.00</b>	<b>323,620,600.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>143,787,688.00</b>	<b>323,620,600.00</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,229,700.00	198,799,570.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	430,000.00	99,424,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	137,127,988.00	25,397,030.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**АХМАДЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		17,732,000
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		17,732,000
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		17,732,000

2132	Бусад урсгал шилжүүлэг		17,732,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,732,000
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0.00	17,732,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		23,085,950
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		12,895,743.63

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн тусгай алба юм.

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь 2024 онд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын мэдээлэл, харилцаа холбоо, цахим технологи ашиглалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангах болон алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, менежментийн шинэлэг арга, хэлбэрийг нэвтрүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх зорилт тавин ажилласан байна.

Дээрх зорилтын дагуу алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол, аюулгүй байдал, эрсдэлийн агуулгын ялгааг салгах, алба хаагч, ажилтны эрх ашиг хөндөгдөж байгаа үйл ажиллагааг судлах, шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлээр Цагдаагийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/47 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр II”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийг зохион байгуулах орон тооны бус дэд зөвлөлийг тус тус баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд 20 ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь тайлант онд санхүүгийн тооцоолох группийн “FISCUS” санхүүгийн програмыг шинээр нэвтрүүлж ажилласан байна

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 сарын 20-ын өдрийн А/247 дүгээр тушаалаар баталсан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.2 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	23,086.0	12,895.7	(10,190.2)
Авлага	610.0	-	(610.0)
Бараа материал	252,728.1	245,219.1	(7,509.0)
Үндсэн хөрөнгө	2,901,423.9	2,943,938.8	42,514.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,177,848.0</b>	<b>3,202,053.7</b>	<b>24,205.7</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,177,848.0	3,202,053.7	24,205.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,177,848.0</b>	<b>3,202,053.7</b>	<b>24,205.7</b>

Дээрх хүснэгтээс харахад оны эцэст төрийн сан дахь ахмадын дансны үлдэгдэл 10.2 сая төгрөгөөр буурч 12,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын данс оны эхнээс 0.6 сая төгрөгөөр буурч оны эцэст үлдэгдэлгүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 245.2 сая төгрөг болж 7.5 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 417.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү ар талын албанаас 21.2 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, бичиг хэрэг, бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаандаа 442,7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, Цагдаагийн газрын 2024 оны Б/13 дугаар тушаалаар 3.1 сая төгрөгийн бараа материалыг акталж, устгасан байна.

Үндсэн хөрөнгө 202.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 49.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, ЦЕГ-ын Санхүү ар талын албанаас 144.8 сая төгрөг бүхий 3 тээврийн хэрэгсэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 255, 264, 272 дугаар тогтоолуудыг үндэслэж аймаг, сумын хэсгийн цагдаа нарт 59.6 сая төгрөгийн үнэ бүхий 23 ширхэг мотоцикл, балансаас баланс хооронд шилжүүлгээр 93.6 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл бүгд 298.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл,

Хууль зүйн дотоод хэргийн яамнаас 89.6 сая төгрөгийн, ЦЕГ-ын санхүү ар талын албанаас 62.7 сая төгрөгийн, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 264 дугаар тогтоолыг үндэслэн 52.5 сая төгрөгийн бүгд 204.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж,

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 267 дугаар тогтоолыг үндэслэн бүгд 22.3 сая төгрөгийн тавилга эд хогшил Нийтдээ 525.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 16 дугаар тогтоолоор 21.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2.7 сая төгрөгийн тавилга эд хогшил бүгд 24.6 сая төгрөгийн 39 нэр төрлийн хөрөнгийг акталж данснаас хассан байна. Мөн аймгийн ИТХурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГазарт нийтдээ 346.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баласад шилжүүлсэн байна.

Тайлант онд 24.2 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан ба Засгийн газрын хувь оролцоо данс 24.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5563.8 сая төгрөг, нийт зарлагыг 5563.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны анх батлагдсан төсөв 5563.8 сая төгрөг ба тодотгосон төсөв 6506.5 сая төгрөг болж анх баталснаас 942.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор тайлант оны 4 дугаар сараас цалин нэмэгдсэн, Сангийн сайдын 2024 оны А/51 дүгээр тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон зэрэгтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Цагдаа гэсэн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6384.8 сая төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 122.6 сая төгрөг оруулж бүгд 6507.5 сая төгрөгийн орлого санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6384.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 163.0 сая төгрөг бүрдүүлж бүгд 6547.9 сая төгрөгийн орлого санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6506.5 сая төгрөг буюу 100 хувьтай ба үндсэн үйл ажиллагааны орлогоос давж биелэгдсэн 40.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зарлагын 76.9 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 2.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 3.2 хувийг хангамж, бараа материалын зардал, 0.3 хувийг норматив зардал, 1.2 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.5 хувийг томилолт, зочны зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 15.4 хувийг бусад урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,504,293.1	5,504,293.1	-	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,002,643.2	1,002,643.2	-	100.0
82315	Байцаан шийтгэх ажиллагаа	550.0	550.0	-	100.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	323,620.6	323,620.6	-	100.0
	<b>Дүн</b>	<b>6,831,106.9</b>	<b>6,831,106.9</b>	-	<b>100.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газраас Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хамгаалалтын зардалд 99.4 сая, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 59.9 сая, аймгийн замын сангаас олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто замын цагдаагийн хяналтгүй хэсэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хурд хэмжиж байна” самбар үнэд 9.4 сая, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 50.5 сая

төгрөгийн сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн сангаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардалд 11.0 сая, аймгийн Засаг даргын тамгын газраас камер арчилгааны зардал болон олон нийтийн цагдаагийн цалин зэрэгт бүгд 48.4 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл болон бусад зардалд, аймгийн Сонгуулийн хорооноос тээвэр шатахууны зардалд 1.1 сая, Алтай сумын ЗДТГ-аас сумын цагдаагийн кабоны засварт 10.0 сая, Дэлүүн сумны Засаг даргын тамгын газраас олон нийтийн цагдаа нарын хувцасны мөнгө 2.0 сая, иргэдийн галт зэвсгийн сургалтын төлбөр 23.4 сая нийтдээ 323.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг бүрдүүлэн ажилласан байна.

Цагдаагийн газар нь 323.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үүнээс байр ашиглалттай холбоотой зардалд 3.0 сая, хангамж бараа материалын зардалд 58.3 сая, норматив зардалд 66.5 сая, эд хогшил худалдан авах зардалд 104.9 сая, томилолт, зочны зардалд 20.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 2.2 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 35.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Ахмадын сангийн дансанд оны эцэст 7.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 32/408 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7181.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 107.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 2211.7 сая төгрөгөөр өссөн ба материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны мэдээллээс цалингийн 171 мэдээлэл, оруулахаас 169 мэдээллийг цаг тухайд нь мэдээлж ажилласан байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 97.2 хувь байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нэг зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Нийт дүн

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тус байгууллагын санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт байхгүй.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага байхгүй.

**5.3 Зөвлөмж**

Зөвлөмж байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								